



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 8/НБ


Улаанбаатар хот

Төвлөрлийг сааруулах үндэсний багийн
ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолын 5.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төвлөрлийг сааруулах үндэсний багийн ажиллах журам”-ыг нэгдүгээр, үндэсний багийн тайлан бичих загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үндэсний багийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа)-т, Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.
3. Үндэсний багийн тогтвортой ажиллуулах үүргийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (С.Энхболд)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 дүгээр
сарын 04 өдрийн 416 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ҮНДЭСНИЙ БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар хавдрын мэс засал, хавдрын хими, бай эмчилгээ, зүрх, судасны ангиографийн оношилгоо, эмчилгээ, мэдрэлийн ангиографийн оношилгоо, эмчилгээ, гэмтлийн мэс засал, зүрхний хэм алдагдал, хоол боловсруулах замын дурангийн оношилгоо, эмчилгээ, яаралтай тусламж, эх барих, эмэгтэйчүүд, хүүхэд нярайн төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эрүүл мэндийн байгууллагаас тухайн тусламж, үйлчилгээг аймаг, дүүрэгт нутагшуулах мэргэшсэн эмч нарын баг /цаашид үндэсний баг гэх/ орон нутагт ажиллахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2 Үндэсний баг нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.3 Үндэсний баг нь орон нутагт оношилж, эмчлэх боломжгүй өвчин эмгэгийг оношлох, эмчлэх хүний нөөцийг бэхжүүлэх, технологи нутагшуулах зорилгоор аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт багаар хамтран ажиллаж, орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх, тэдэнд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх тогтвортой үйл ажиллагааг зохион байгуулна.

1.4 Үндэсний багийн үйл ажиллагаа нь төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд ирж тусламж, үйлчилгээ авах иргэдийн урсгалыг сааруулж, иргэд орон зайг туулахад цаг хугацаа алдахгүй, хамгийн ойр байрлах эрүүл мэндийн байгууллагаас хүлээгдэл чирэгдэлгүй, чанартай нэн шаардлагатай тусламж үйлчилгээг авч, санхүүгийн дарамтаас чөлөөлөгдөнө.

1.5 Үндэсний багийн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн эрүүл мэндийн байгууллага мэргэшсэн хүний нөөцөөр хангагдаж, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдэж тогтвортой үйл ажиллагаа бий болно.

Хоёр. Үндэсний багийн удирдлага, зохион байгуулалт

2.1 Аймаг, орон нутгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг нь өөрийн байгууллагад үндэсний баг ажиллуулах тухай хүсэлтийг Эмнэлгийн тусламжийн бодлогын газарт ирүүлнэ.

2.2 Орон нутгийн хүсэлт, хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаан, үндсэн үзүүлэлтэд үндэслэн Үндэсний багийн тусламж, үйлчилгээний төрөл, бүрэлдэхүүн, ажиллах хугацааг Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга тогтооно.

2.3. Үндэсний багийн албан хаагч хөдөө, орон нутагт ажиллах хугацаанд үндсэн ажлыг харьяалах байгууллагын эмнэлзүй хариуцсан дэд захирал эсвэл

эмчилгээ эрхэлсэн орлогч дарга хавсран гүйцэтгэх эмчийг томилон үндсэн үйл ажиллагааг доголдуулахгүйгээр зохион байгуулж ажиллуулна.

2.4. Орон нутгийн Эрүүл мэндийн газар нь төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг бэхжүүлэх зорилгоор үндэсний багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2.5. Үндэсний багтай хамтран ажиллах, дадлагажих, суралцах, цаашид тогтвор суурьшилтай ажиллах хүний нөөцтэй гэрээ байгуулж, ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Орон нутгийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллага хариуцна.

2.6. Үндэсний баг ажиллахаас 14 хоногоос 1 сарын өмнө ойр байрлах аймаг, суманд зар хүргэсэн байна.

2.7. Үндэсний баг нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.7.1. орон нутгийн иргэдэд төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээ үзүүлэх;

2.7.2. орон нутгийн эмч, мэргэжилтнүүдийг сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх, туршлагаа солилцох;

2.7.3. аймгийн эрүүл мэндийн байгууллагад төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг бэхжүүлэхэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх.

2.8. Үндэсний баг нь тасаг, нэгжийн дотоод зохион байгуулалт хийхэд зөвлөн тусалж, санал гаргаж болно.

2.9. Эрүүл мэндийн байгууллага нь үндэсний баг ажиллахын өмнө тусламж, үйлчилгээ авах өвчтөний мэдээлэл, шаардагдах тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийг урьдчилан хангасан байна.

2.10. Үндэсний баг орон нутагт ажиллах хугацаанд зохион байгуулах сургалтын сэдэв, хугацаа, хэлбэрийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга батална.

2.11. Үндэсний багийн зохион байгуулах сургалтын чанар, үр дүнд үнэлгээ хийж сургалтын хөтөлбөрийг бүрэн хангасан эмч, мэргэжилтэнд сургалтын гэрчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төв олгоно.

2.12. Үндэсний багийн ахлагч нар тухайн аймагт ажилласан тухай тайланг Хавсралт 2-т заасан загварын дагуу Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газарт аймаг, орон нутгаас ирснээс хойш 10 хоногийн дотор ирүүлнэ.

Гурав. Үндэсний багийн зардал, тусламж үйлчилгээний төлбөрийн санхүүжилтийн зохицуулга

3.1. Үндэсний багийн эмч, мэргэжилтний унаа, унааны аюулгүй байдал, хоолны зардал, тусламж үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, ажилласан хугацааны мөнгөн урамшууллыг орон нутгийн Эрүүл мэндийн байгууллага хариуцна.

3.2. Үндэсний баг ажиллах хугацаанд тухайн байгууллагын даатгалын бүртгэлийн цахим эрхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нээнэ.

3.3. Үндэсний багийн үзүүлсэн тусламж үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийг үндсэн тусламж үйлчилгээнээс ялгаатайгаар “Үндэсний багийн үзүүлсэн тусламж үйлчилгээ” гэж Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас нэхэмжилнэ.

3.4. Үндэсний багийн ажиллах хугацаанд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолд заасан тарифын дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар олгоно.

3.5. Үндэсний багийн эмч, мэргэжилтнийг орон нутагт ажиллах үед үндсэн цалинг харьяалах байгууллага олгоно.

Дөрөв. Бусад

4.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

-oOo-

Эрүүл мэндийн сайдын 2025 оны ... дүгээр
сарын ... өдрийн ... дугаар ... тушаалын
хоёрдугаар хавсралт

ҮНДЭСНИЙ БАГИЙН ТАЙЛАН БИЧИХ ЗАГВАР

Ерөнхий зүйл.

1. Үндэсний багийн гишүүдийн тайлан, тулгамдсан асуудал, шийдвэрлэх санал, зөвлөмжийг багийн ахлагч нэгтгэнэ.
2. Тайланг Аймаг, орон нутгаас ирснээс хойш 10 хоногийн дотор Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газарт ирүүлнэ.

Тайланд тусгах мэдээлэл.

1. Очиж ажилласан аймаг, Эрүүл мэндийн байгууллагын нэр;
2. Ажилласан он сар өдөр;
3. Нийт хоног;
4. Үндэсний багийн эмч мэргэжилтнүүдийн мэдээллийг дараах хүснэгтийн дагуу ирүүлнэ:

№	Овог, нэр	Харьяа байгууллага	Мэргэшсэн байдал	Цол, зэрэг	Утасны дугаар.	И-мэйл хаяг

4. Үндэсний багийн эмч мэргэжилтний үзүүлсэн тусламж үйлчилгээний ерөнхий мэдээлэл;
5. Аймаг, орон нутгийн эмч. мэргэжилтэнд зохион байгуулсан сургалтын сэдэв, хугацаа, хэлбэрийн талаар (лекц, ажлын байрны сургалт) ;
6. Сургалтын материал, зураг хавсаргах;
7. Өмнөх удаагийн үндэсний багийн заавар, зөвлөмжийн хэрэгжилт;
8. Тулгамдаж буй асуудал;
9. Үндэсний багийн дүгнэлт, заавар, зөвлөмж;
10. Үндэсний багийн тусламж, үйлчилгээний тоон мэдээллийг дараах загвараар ирүүлнэ:

1.	Аймаг:	Огноо	Үзүүлэлт
2.	Хоног		
3.	Эмч, мэргэжилтний тоо		
Тусламж үйлчилгээний мэдээлэл			
4.	Хавдар	Амбулаторийн үзлэг	
		Ангиографийн оношилгоо	
		Хэвлийн ангиографийн эмчилгээ	
		Хавдрын оношилгоо (ЭХО)	
		Хавдрын мэс засал	
		Хими эмчилгээ /үзлэг	
		Хими эмчилгээ	
		Бай эмчилгээ	
		Хими+бай эмчилгээ	
5.	Зүрхний шигдээс	Амбулаторийн үзлэг	
		Ангиографийн оношилгоо	
		Ангиографийн эмчилгээ	
6.	Тархины харвалт цус	Амбулаторийн үзлэг	
		Ангиографийн оношилгоо	
		Ангиографийн эмчилгээ	
7.	Зүрхний алдагдал хэм	Амбулаторийн үзлэг	
		Оношилгоо	
		Эмчилгээ /холтер	
8.	Гэмтлийн мэс засал	Үзлэг	
		Оношилгоо	
		Мэс засал	
9.		Хүүхдийн үзлэг /оношилгоо	
10.		Ургийн үзлэг/оношилгоо	
11.	Бусад	Нярайн үзлэг / оношилгоо	
12.		Эх барихын үзлэг /оношилгоо	
13.		Эмэгтэйчүүдийн үзлэг / оношилгоо	
14.		Эмэгтэйчүүдийн эмчилгээ	
15.		Насанд хүрэгчдийн үзлэг	
16.			
17.			
18.			